



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 03 дугаар сарын 10-ны өдөр

№ 39

Улаанбаатар хот

“Азия Пасифик Пропертиз” Хувьцаат компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт

2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа “АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХКомпани нь “Фискал аудит” ХХК-иар аудит хийлгэсэн.

2013 оны балансын тухай мэдээлэл:

Үзүүлэлтүүд	2012 он	2013 он	өөрчлөлт /төг
Эргэлтийн хөрөнгө	562,056,227.90	99,709,291.67	(462,346,936.23)
Эргэлтийн бус хөрөнгө	1,486,856,393.55	726,421,934.48	(760,434,459.07)
Нийт өр төлбөр	1,764,944,479.83	636,578,375.97	(1,128,366,103.86)
Нийт эзэмшигчдийн өмч	283,968,141.62	189,552,850.18	(94,415,291.44)
Нийт хөрөнгө	2,048,912,621.45	826,131,226.15	(1,222,781,395.30)

Эргэлтийн хөрөнгө:

“Эй Пи Ай Пи” ХХК-нд өгөх 313,200,000 төгрөгийн өглөгийг “Эй Пи Ай Пи” ХХК-иас авах авлага руу нэгтгэн хаасан.

Эргэлтийн бус хөрөнгө:

“Монголиан Пропертиз” ХХК-тай байгуулсан 2012 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн гэрээгээр бүртгэсэн 760,636,620 төгрөгийн гүйлгээг барилга барих зөвшөөрөл аваагүй байгаа тул эрх зүйн хувьд үндэслэлгүй байсан гэж үзээд буцаасан.

2012 оны аудитын залруулгыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд авч, 48,301,086 төгрөгийн “зохион байгуулалтын зардал” биет бус хөрөнгийг бүртгэсэн.

Нийт өр төлбөр:

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн өөрчлөлтөөс өр төлбөр буурсан. Мөн хөрөнгө оруулагч Дэвид Вивианд өгөх 57 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөө барагдуулсан. Тайлант хугацаанд буюу 2013 онд нийт 119.4 сая төгрөгийн зардал

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот

гаргасан бөгөөд түрээсийн орлого 24,9 сая төгрөг олсон ба үүнээс 94,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Тайлант хугацаанд нийт 119,4 сая төгрөгийн зардал гарсанаас :

элэгдлийн зардал 48,2 сая төгрөг /нийт зардлын 40%/

үндсэн болон нэмэгдэл цалин 37,3 сая /нийт зардлын 31%/

мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал 8,3 сая төгрөг /нийт зардлын 7%/

нийгмийн даатгалын шимтгэл 4,5 сая /нийт зардлын 4%/

судалгааны зардал 4,9 сая төгрөг /нийт зардлын 4%/

ХЭХ-ыг зохион байгуулах зардал 3,3 сая төгрөг /APS 2.5 сая төгрөгийн гэрээ хийсэн/
/нийт зардлын 3%/

сургалтын зардал 2,1 сая төгрөг, /нийт зардлын 2%/

жилийн хураамжийн төлбөр 1,6 сая төгрөг /нийт зардлын 1%/

үйл ажиллагааны бусад зардал 9,2 сая төгрөг /нийт зардлын 8%/-ийн зардал тус тус гарсан байна. ТУЗ-ийн гишүүдэд 2013 онд нийт 4 удаагийн хурлаар 2,0 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон. “Азиа Пасифик Пропертис” хувьцаат компанийн гүйцэтгэх захиралд 2013 онд нийт олгосон цалин урамшуулал нь 21,5 сая төгрөг болно. Гүйцэтгэх захирал Д.Галбадрах нь 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажилласан. Компанийн үйл ажиллагааны хувьд барилга барих зөвшөөрөл авахаар хөөцөлдөн ажиллаж байна. Мөн манай компанийн үндсэн үйл ажиллагаа болох газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр судалгаа шинжилгээний баг хамт олон төсөл боловсруулан судалгааны ажлыг үргэлжлүүлсээр байгаа ба уг төслийг 3 удаагийн давтамжтай хийсэн судалгаа шинжилгээний үндсэн дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулсаар байх болно. Судалгааны ажил маш үр дүнтэй байгаа бөгөөд органик бордоогоор бүх төрлийн нарийн ногоо болон ургамал, мод, арц зэрэг дээр судалгаа явуулж байгаа ба сар бүр судалгааны ажлын тайланг гаргаж гарах өөрчлөлт, өсөлт, хөгжлийн талаар танилцаж, үйл явцыг мэдэж байгаа болно. 2013 онд компанийн хувьд хувьцаа хуваах төслийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох материалуудаа хүргүүлснээр хувьцаа хуваах шийдвэрийг баталж 352,770 ширхэг энгийн хувьцаа хуваагдан 3,527,700 ширхэг энгийн хувьцаатай болсныг хувьцаа эзэмшигч нартаа дуулгахад таатай байна. Мөн 2013 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

ХУРЛЫН ДАРГА:

УЛААНБААТАР ХОТ

АЗИА ПАСИФИК
ПРОПЕРТИС

/ Д. ГАЛБАДРАХ /

Утас: 94991014 / 7730 ХК / Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашигийн тухай:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, компанийн 2013 оны санхүүгийн тайланг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тайлант хугацаанд буюу 2013 онд нийт 119,4 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд түрээсийн орлого 24,9 сая төгрөг олсон ба үүнээс 94,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан зэргийг харгалзан үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилаагүй шалтгаан үндэслэлийг 2013 оны үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тайлбарлан тусгахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАЛБАДРАХ


“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг
нэмэгдүүлэх төслийг сайшаах тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалтыг
үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 100 /нэг зуун/ төгрөг болгон өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төслийг сайшаасугай.
2. “Азия Пасифик Пропертиз” ХК-ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан мэдээлэх, төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэлийг хангахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 03-р сарын 10-ны өдөр

№ 42

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг зөвшөөрөх тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн дүрэмд дараах агуулга бүхий нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхийг зөвшөөрсүгэй.

1. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төсөлтэй холбогдуулан дүрэмд дараах нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 1.1. Дүрмийн 4.1 дэх заалтыг “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3527700 ширхэг хувьцаанаас бүрдэнэ.
 - 1.2. Дүрмийн 4.2-ийн 2 дах өгүүлбэрийг “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1752650 ширхэг энгийн хувьцаа байна”

Компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, зардлыг хэмнэх зорилт зэрэгтэй уялдуулан ТУЗ-ийн хуралд хамаарах заалтыг дараах байдлаар өөрчлөх

- 1.3. Дүрмийн 7.30-ийг “ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулна” гэж тус тус өөрчлөх
2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ ХК Д.ГАЛБАДРАХ



Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 03 дугаар сарын 10-ны өдөр

№ 43

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан
хуралдуулах тухай:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагт Монгол улс 14220 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Олимпийн гудамж 16 Реженси Резиденс, 202 тоотын хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төслийг батлах;
 - 2.3. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлах;
 - 2.4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах;
 - 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2014 оны 03 дугаар сарын 15-наас эхлэн нийтлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2014 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
5. Дараах бичиг баримтуудыг компанийн өөрийн байр, Азия Пасифик Секьюритис БДК болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг БДК дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас өмнө 4 дүгээр сарын 1-нээс эхлэн танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

аяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот




APR

Азия Пасифик Пропертиз ХК

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
 - 5.2. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
 - 5.3. Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төсөл;
 - 5.4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл;
 - 5.5. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга;
 - 5.6. Ногдол ашгийн тухай;
6. Энэхүү тогтоолын 5 дугаар заалтын хэрэгжүүлэх үүргийг дор дурьдсан нэр бүхий албан тушаалтанд хариуцуулсугай.
- 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ТУЗ-ийн тогтоолын хуулбарыг Э.Булгантамир;
 - 6.2. Компанийн 2013 оны санхүүгийн тайлан, түүний танилцуулгыг нягтлан бодогч Д. Мөнхдэлгэр
 - 6.3. Үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Галбадрах
 - 6.4. Ногдол ашгийн тухай асуудлыг Галбадрах,
 - 6.5. Хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төслийг Б.Аюуш, Э.Булгантамир;
 - 6.6. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулгыг Э.Булгантамир;
 - 6.7. Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг Э.Булгантамир
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг Хавсралт 2-оор баталсугай.
8. Хурлын санал авах хуудасны загварыг Хавсралт 3-аар баталсугай.
9. Санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагаар тогтоосугай.
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Азия Пасифик Секьюритиз БДК/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APR

Азиа Пасифик Пропертис ХК

2014 оны 03-р сарын 10-ны өдөр

Хавсралт 2

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хурал зохион байгуулах комисс томилох тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагт Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж 16 Реженси Резиденс 202 тоотын хурлын танхимд хуралдах болсон тул хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /Д.Галбадрах/-ыг томилсугай.
2. Хурал зохион байгуулах комиссоор “Азиа Пасифик Секьюритис” БДК-ийг томилсугай.
3. Хурал зохион байгуулах комиссын даргаар /Д.Нармандах/-ыг томилсугай.
4. Хурал зохион байгуулах комиссыг тооллогын комиссоор ажиллуулахаар томилсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлын материалыг бусад холбогдох брокер дилерийн компаниудад 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор тарааж мэдээлэл хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Д.Нармандах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 05-р сарын 10-ны өдөр

Хавсралт 3

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Санал авах хуудасны загварыг батлах тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагт Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпийн гудамж 16 Реженси Резиденс 202 тоотын хурлын танхимд хуралдах болсон тул санал авах хуудасны загварыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 03 сарын 10-ны өдөр

№ 44

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хамтран ажиллах байгууллагыг сонгох тухай :

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах болон зуучлалын үүрэг гүйцэтгэж, хамтран ажиллах гэрээ байгуулах компаниар “Азия Пасифик Секьюритис” ХХК-ийг сонгосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссоор томилогдсон тул Компанийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг үүрэг болгосугай.
3. “Азия Пасифик Секьюритис” ХХК-тай байгуулах гэрээг хавсралтаар баталж, гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурахыг Гүцэтгэх захирал /Д.Галбадрах/-д зөвшөөрсүгэй.
4. “Азия Пасифик Секьюритис” ХХК-д төлөх гэрээний төлбөрийн дүнг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300450 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 03-р сарын 10-ны өдөр

№ 45

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх тухай :

Компанийн нэр дэвшүүлэх хорооны 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэр дэвшүүлэх хорооны хуралдаанаар 2014 оны компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зорилгоор “Азия Пасифик Пропертиз” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

Ердийн гишүүнд: Ли Майкл Кашелл

Бордухын Цэндсүрэн

Дангаасүрэнгийн Галбадрах

Энхбатын Одбаяр

Бандийн Бямбажав

Чимэддоржийн Энхбаяр

Хараат бус гишүүнд: Базарын Аюуш

Будхүүгийн Ариунболор

Дэмчигжавын Намсрайжав нарыг тус тус нэр дэвшүүлж байна.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай:

Компанийн 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн ТУЗ-ийн 2014 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. 2014 оны зардлын төсвийн тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Д.ГАЛБАДРАХ